



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/132/-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он | Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: П. Ганцолмон Утас: 70157405 Цахим хаяг: ulistaivanaudit@gmail.com |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 3. Аудитын тайлан | 9 |
| 3.1 Ерөнхий зүйл | 9 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Материаллаг байдал..... | 10 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 12 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 12 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 12 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 12 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 12 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 13 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 116

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07122380

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------------|---|------------------------|------------------------|
| 1.00 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 51,863,200.00 | 54,106,295.00 |
| 35.00 | БАРАА МАТЕРИАЛ | 51,863,200.00 | 54,106,295.00 |
| 35,400.00 | Хангамжийн материал | 51,783,200.00 | 54,026,295.00 |
| 35,410.00 | Бичиг хэргийн материал | 922,900.00 | 1,672,900.00 |
| 35,420.00 | Аж ахуйн материал | 49,681,765.00 | 49,768,165.00 |
| 35,440.00 | Түлш, шатах тослох материал | 890,000.00 | 380,000.00 |
| 35,460.00 | Хүнсний материал | 196,835.00 | 2,113,530.00 |
| 35,470.00 | Бусад хангамжийн материал | 91,700.00 | 91,700.00 |
| 35,600.00 | Мал амьтад | 80,000.00 | 80,000.00 |
| 2.00 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 197,206,829.59 | 187,316,185.91 |
| 39.00 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 197,206,829.59 | 187,316,185.91 |
| 39,200.00 | Биет хөрөнгө | 193,828,829.59 | 183,938,185.91 |
| 39,201.00 | Барилга, байгууламж, орон сууц | 203,806,196.84 | 203,806,196.84 |
| 39,202.00 | Хуримтлагдсан элэгдэл | (22,090,321.93) | (28,067,347.57) |
| 39,205.00 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 10,063,896.50 | 10,063,896.50 |
| 39,206.00 | Хуримтлагдсан элэгдэл | (777,025.00) | (3,893,123.56) |
| 39,207.00 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,600,259.88 | 3,600,259.88 |
| 39,208.00 | Хуримтлагдсан элэгдэл | (2,088,416.70) | (2,885,936.18) |
| 39,214.00 | Бусад үндсэн хөрөнгө | 5,448,000.00 | 5,448,000.00 |
| 39,215.00 | Хуримтлагдсан элэгдэл | (5,448,000.00) | (5,448,000.00) |
| 39,217.00 | Ном | 1,314,240.00 | 1,314,240.00 |
| 39,300.00 | Биет бус хөрөнгө | 3,378,000.00 | 3,378,000.00 |
| 39,301.00 | Програм хангамж | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 39,302.00 | Хуримтлагдсан элэгдэл | (1,450,000.00) | (1,450,000.00) |
| 39,303.00 | Бусад биет бус хөрөнгө | 3,378,000.00 | 3,378,000.00 |
| 3.00 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 249,070,029.59 | 241,422,480.91 |
| 5.00 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 249,070,029.59 | 241,422,480.91 |
| 51.00 | Засгийн газрын хувь оролцоо | 249,070,029.59 | 241,422,480.91 |
| 51,100.00 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 314,706,769.00 | 314,706,769.00 |
| 51,200.00 | Хуримтлагдсан үр дүн | (88,334,051.51) | (95,981,600.19) |
| 51,210.00 | Өмнөх үеийн үр дүн | (124,393,101.03) | (88,334,051.51) |
| 51,220.00 | Тайлант үеийн үр дүн | 36,059,049.52 | (7,647,548.68) |
| 51,300.00 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,697,312.10 | 22,697,312.10 |
| 6.00 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 249,070,029.59 | 241,422,480.91 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 295,649,483.80 | 240,373,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 52,266,083.80 | 645,600.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 52,266,083.80 | 645,600.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,107,939.80 | 645,600.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,107,939.80 | 645,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 40,158,144.00 | 0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 243,383,400.00 | 239,728,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 234,595,900.00 | 231,590,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 234,595,900.00 | 231,590,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 8,787,500.00 | 8,137,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 8,787,500.00 | 8,137,500.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 259,590,433.96 | 248,021,448.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 259,590,433.96 | 248,021,448.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 223,278,152.15 | 239,474,413.28 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 164,130,551.93 | 174,901,214.72 |
| 210101 | Үндсэн цалин | 135,905,252.46 | 143,022,420.28 |
| 210104 | Урамшуулал | 12,752,202.80 | 12,909,382.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,473,096.67 | 18,969,411.84 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,060,205.00 | 24,872,446.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,024,337.38 | 18,291,746.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 403,124.70 | 1,726,985.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,190,193.00 | 1,286,505.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 183,710.39 | 322,249.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,258,839.53 | 3,244,960.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,598,095.00 | 8,387,208.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,580,095.00 | 4,360,608.06 |
| 210302 | Түлш, халаалт | 2,834,000.00 | 1,840,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,184,000.00 | 2,186,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,042,775.00 | 4,578,605.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,564,800.00 | 597,355.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,993,075.00 | 2,110,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 530,000.00 | 530,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 370,000.00 | 87,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,584,900.00 | 1,222,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 12,033,500.00 | 14,677,395.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 160,000.00 | 666,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,873,500.00 | 14,010,895.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 180,000.00 | 240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 180,000.00 | 240,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 0 | 0 |
| 2107 | Томилот, зочны зардал | 0 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилот | 0 | 84,000.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 544,000.00 | 1,652,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 1,004,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,689,025.22 | 10,080,643.68 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 642,500.00 | 190,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,046,525.22 | 9,890,643.68 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,312,281.81 | 8,547,035.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,223,405.00 | 260,291.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,223,405.00 | 260,291.94 |
| 213404 | Хөрөнгийн | 0 | 0 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 33,808,876.81 | 7,011,093.46 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,808,876.81 | 7,011,093.46 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 36,059,049.84 | -7,647,548.68 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.32 | 0 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0.32 | 0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 36,059,049.52 | -7,647,548.68 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -124,393,101.03 | 213,010,980.07 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -124,393,101.03 | 213,010,980.07 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 36,059,049.52 | 36,059,049.52 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -88,334,051.51 | 249,070,029.59 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -88,334,051.51 | 249,070,029.59 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -88,334,051.51 | 249,070,029.59 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -7,647,548.68 | -7,647,548.68 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 314,706,769.00 | 22,697,312.10 | -95,981,600.19 | 241,422,480.91 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 243,383,400.00 | 239,728,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 243,383,400.00 | 239,728,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 234,595,900.00 | 231,590,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 234,595,900.00 | 231,590,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 8,787,500.00 | 8,137,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 8,787,500.00 | 8,137,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 243,383,400.00 | 239,728,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 243,383,400.00 | 239,728,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 207,071,118.19 | 231,181,264.60 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 162,833,522.89 | 174,901,214.71 |
| 210101 | Үндсэн цалин | 135,880,995.82 | 143,022,420.27 |
| 210104 | Урамшуулал | 11,479,430.40 | 12,909,382.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,473,096.67 | 18,969,411.84 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,878,780.30 | 24,872,446.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,024,337.38 | 18,291,746.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 221,700.00 | 1,726,985.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,190,193.00 | 1,286,505.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 183,710.39 | 322,249.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,258,839.53 | 3,244,960.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,564,095.00 | 7,877,208.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,580,095.00 | 4,360,608.06 |
| 210302 | Түлш, халаалт | 1,800,000.00 | 1,330,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,184,000.00 | 2,186,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,011,375.00 | 3,977,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,409,800.00 | 619,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,110,675.00 | 2,110,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 530,000.00 | 530,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 91,700.00 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 370,000.00 | 87,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,499,200.00 | 599,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 8,261,845.00 | 16,528,090.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 160,000.00 | 600,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,101,845.00 | 15,927,590.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 180,000.00 | 240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 180,000.00 | 240,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0 | 84,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 544,000.00 | 1,652,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 1,004,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 0 |

| | | | |
|-------------|---|----------------------|---------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 797,500.00 | 1,047,855.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 797,500.00 | 1,047,855.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,312,281.81 | 8,547,035.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,223,405.00 | 260,291.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,223,405.00 | 260,291.94 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 33,808,876.81 | 7,011,093.46 |
| 213502 | Хаагдсан данс | 0 | 0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,808,876.81 | 7,011,093.46 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|---|-----------------------|-----------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 241,490,800.00 | 232,456,914.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 241,490,800.00 | 232,456,914.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 240,210,800.00 | 231,181,264.60 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 179,059,000.00 | 174,901,214.71 |
| 210101 | Үндсэн цалин | 145,221,000.00 | 143,022,420.27 |
| 210104 | Урамшуулал | 14,605,000.00 | 12,909,382.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,233,000.00 | 18,969,411.84 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,614,000.00 | 24,872,446.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,879,000.00 | 18,291,746.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,934,000.00 | 1,726,985.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,547,000.00 | 1,286,505.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 390,000.00 | 322,249.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,864,000.00 | 3,244,960.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,900,000.00 | 7,877,208.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,400,000.00 | 4,360,608.06 |
| 210302 | Түлш, халаалт | 3,000,000.00 | 1,330,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 2,186,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,998,000.00 | 3,977,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 630,000.00 | 619,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,112,000.00 | 2,110,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 530,000.00 | 530,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 30,000.00 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,000.00 | 87,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 599,700.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 2105 | Нормативт зардал | 17,489,800.00 | 16,528,090.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 601,100.00 | 600,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,888,700.00 | 15,927,590.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 240,000.00 | 240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 240,000.00 | 240,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 200,000.00 | 84,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 84,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,660,000.00 | 1,652,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,012,000.00 | 1,004,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 648,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,050,000.00 | 1,047,855.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,050,000.00 | 1,047,855.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0 | 0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,280,000.00 | 1,275,650.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 241,490,800.00 | 232,456,914.60 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 231,590,800.00 | 224,579,706.54 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 231,590,800.00 | 224,579,706.54 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 9,900,000.00 | 7,877,208.06 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 9,900,000.00 | 7,877,208.06 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П. Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 243.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 248.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.1 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54.1 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 22.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 0.6 сая төгрөгийн материалыг шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 19.3 сая төгрөгийн материалыг зарцуулан, 1.3 сая төгрөгийн материалыг сумын онцгой комиссын шийдвэрээр зарцуулж, 0.4 сая төгрөгийн материалыг шилжүүлж бүртгэнсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 229.1 сая төгрөгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 241.4 сая төгрөг болж тайлант оны алдагдал 7.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 276.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 35.4 сая төгрөгөөр бууруулж, 241.5 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 241.5 сая төгрөгийн төсөв баталснаас 231.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 9.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 231.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 8.1 сая төгрөг нийт 239.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 232.5 сая төгрөгийг зарцуулж 7.0 сая төгрөгийг улсын төсөвт, 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 232.5 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардлыг 4.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.0 сая төгрөгөөр, , норматив зардлыг 1.0 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ гараагүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын тайланд хүүхдээ асарч буй эхийн ажил олгогчоос төлөх шиймтгэлийг зөрүүтэй тайлагнасан 0.4 сая төгрөгийг тодруулж залруулга хийх шаардлагатай.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримтын бүрдэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 327.1 сая төгрөгийн 15 мэдээллээс 43.7 сая төгрөгийн 13 гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлэн ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгээгүй болно.

4.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

4.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, шуудан холбооны зардал 7.0 сая төгрөгийг хоорондын тооцоо үүсгээгүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурель сууриар хөтөлнө. заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын....."үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансныхуулийн хэрэгжилтийг цахим цэснээс тулган баталгаажуулахад 44% байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй болно.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг | 4 | 7.9 | | | | | 4 | 7.9 | | |